

АМРАГЧ ХҮҮХДҮҮД НЬ АМАРЧ АМЖДАГГҮЙ ХҮҮХДИЙН ЗУСЛАН

Хөдөөний айлын хөлний авдараас ялимгүй өндөр чамдам чирсэн хүүхдүүд зуслангийн талбайд цуваа үүсгэн зогсоно. Хүүхдүүдийн зуны чухал нэг мөрөөдөл бол яахын аргагүй энэ зуслан. Тэр тусмаа зуны ээлжинд нь амжиж бүртгүүлнэ гэдэг хамгийн чухал зүйл. Аймгийн төвөөсөө 60км зайд орших шувуун дээвэртэй өнгө өнгийн модон байшингаар өөрийгөө гоёсон энэ зуслан 1962 оноос хойш одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулсаар иржээ. Тэд анх 7 гэр, 40 амрагч хүүхэд, 23 ажилтантай эхэлсэн. Ёстой л хүүхдийн сайн сайхны төлөө гэсэн хүмүүс нэг зорилго, нэг эв нэгдлээр ажиллаж байсныг нутгийн бүх хүмүүс хүлээн зөвшөөрнө. Тэр ч бүү хэл 1986 онд улс үүнийг хүлээн зөвшөөрч 14 сая төгрөгний санхүүжилт олгож байсан. Цаг хугацаа өнгөрөх тусам юмс гэрлийн хурдаар хөгжиж бас өөрчлөгдсөн. Өвгөнжаргалант зуслан ч үүнтэй адил өөрчлөгдсөн. 7 гэр нь 10 гаруй модон байшин болж, 23 ажилтан нь 2дахин үржигдэж, 40 амрагч хүүхдүүд 400 болтлоо өөрчлөгджээ. Үүнтэй зэрэгцээд үйл ажиллагаа, үйлчилгээ чанар ч бас өөрчлөгдсөн. Амрагч хүүхдүүд амжиж амраагүй байхад албан байгууллага, ангийн нийллэг, аль нэг намын дарга цэрэг ирж амардаг болсон нь энэ зуслангийн хамгийн том өөрчлөлт байлаа.

ХҮҮХДИЙН ДУУ НАЙРНЫ ДУУ

Хангайн сүрлэг өндөр уулс, хоржигнон урсах гол горхи, үндсээ газар луу тэлж өөрөө тэнгэр лүү ургасан өргөн их ой модод гээд энэ

зусланд байгалийн баялгаас өөр зүйл алга. Өнгө өнгийн модон байшингаас цуурайтдаг байсан өнөөх хүүхдийн дуунууд хаашаа сарнин одсоныг би ч мэдэхгүй та ч мэдэхгүй. Энэ бол зөвхөн зуслангийн ажилчид, дарга нарын мэдэж байгаа ганц зүйл нь байх. Магадгүй соёлын төвөөс согтуу хүмүүс найрлан гарахдаа үргээчихсэн юм болов уу. Аль эсвэл ангийн нийллэг хийж байсан ах эгч нар аваад явчихсан юм болов уу. Ямартай ч энэ зусланд байгалийн баялгаас өөр зүйл алга. Зуны 3 сардаа багтаж ирдэг байсан 10 ээлжийн 4000 хүүхдийн сурч боловсорч, хөгжих эрхийг хааш нь хэн аваад нуучив. Нуусныг нь анзаарсан юм болов уу томчууд. Анзаарсан болоод л хүүхдийн зусланд хөгжиж цэнгээд, хөөрөн баясалдаад байгаа байх нь.

ХҮҮХДИЙН ЗУРАГ СҮГ ЗУРАГ

Өвгөнжаргалант зуслан нь “Баянхонгор аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар”-т 1997 оноос хойш өнөөдрийг хүртэл харьяалагдсаар ирсэн байдаг. Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үүдээр ороход л хүүхдийн энерги хүлээн авч угтдаг байсан. Хүүхдийн төлөө байгууллага биш гэж хэлэхвий гэсэн шиг хаалганы хажуугийн ханаар дүүрэн хүүхдийн зурагнууд. Хамгийн дээд буланд байгаа зургийг сайн ажвал цагаан цамцан дээрээ улаан бүч зүүсэн жаалхүү хоолны шар бүрээгээ үлээж байгаа харагдана. Нүдээ зүүн тал руу нь ахиулаад нэг гүйлгээд харвал соёлын төвд оройн бүжигэнд орж байгаа амрагч хүүхдүүдийн дүр зураг. Үргэлжлүүлээд доош гүйлгээд харвал төмөр аяга таваг бариад хоолондоо оочирлож байгаа амрагч хүүхдүүд. Бүлгийн багш, найз нөхөд, тоглоом наадгай, тогооч эгч, манаач ах гээд зуслангийн хамгийн гол дурсамжуудыг энэ

ханан дээрх зурагнуудаас харж болохоор байлаа. Он оноор нь, бүлэг бүлгээр нь жагсааж тавьсан энэ зурагнуудаас хүүхэд насны гэгээн дурсамж үнэртэнэ. Бас нэг зүйл тодоос тод харагдана. Жил ирэх тусам зурган дээр байсан зуун хүүхэд 6 улхнаа болсон байх нь гайхалтай. Хэн нэгэнтэй ярилцалгүйгээр, хэн нэгнээс асуулгүйгээр, хэн нэгнээр хэлүүлэлгүйгээр анх удаа би зураг харж хариулт олсон. Өдөр болгон энэ хананы хажуугаар явдаг зуслангийн ажилчид, зуслангийн дарга нар эндээс яг юу олж хардаг юм бол доо. Зураг түүх өгүүлнэ гээд л өнгөрдөг байх. Нээрэн л түүх өгүүлсэн, он удаан жил болж шинэчлэгдэж солигдохоо мэдэхгүй хадны сүг зураг шиг л болж дээ.

ХҮҮХДИЙН ӨРГӨӨ ХҮМҮҮСИЙН БАЯР

Өвгөнжаргалант хүүхдийн зуслан өөрийн гэсэн хөтөлбөр, өөрийн гэсэн орчин, өөрийн гэсэн барилга байгууламжтай болоод 60 гаруй жилийг ардаа үдсэн. Харин сүүлийн жилүүдэд амрагч хүүхдүүдээ бас үдээд байх шиг. Зуны 3 сардаа л гэхэд 7 хоногоор 10 ээлж авч нэг ээлжиндээ 400 гаруй амрагч хүүхдүүд авдаг байсан зуслан одоо 5 ээлж авч чадаж байвал их юм. 6 сарын 26 өдрөөс эхлээд 7 сарын 2 хүртэл 1р ээлж авна. Үргэлжлүүлээд 2р ээлжээ аваад 7сарын 9нд 3р ээлжээ авах ёстой. Гэтэл найр наадамд хайртай томчуудынхаа ачаар хүүхдүүд 3р ээлжэнд явж чадахгүйд хүрнэ. Амралтын 3 бааз байсаар байтал хүүхдийн зусланд очиж наадам тэмдгэлдэг томчуудад хэн нэгэн хаанаас ч юм гарч ирээд хариуцлага тооцохгүй л байх даа. Ангийн нийллэг, уулзалт нэрийдлээр хүүхэд чуулсан хүүхдийн зусланг архидалтын чуулга болгодог аймгийн үе үеийн төгсөгч нарт багш нар нь ядаж муу дүн тавихгүй л байх даа. Алдарт Шаргалжуут рашаан сувилал хаяанд

нь байхад амарч, сувилуулах гэж хүүхдийн зуслан зорьдог хүмүүсийг эмч нарт хэлээд тариулах ёстой юу. Олон биш ганц байгаа хүүхдийн зуслангаа хүн бүр хүүхдийн зуслан гэж хардаг байгаасай. Амралтын газар биш, амарч сувилуулдаг газар биш, архидан согтуурдаг газар бүр биш хүүхдийн зуслан шүү.

Хөвчийн ой хөхрөн униартсан

Хөхөө шувуу хөөрөн донгодсон

Гоёмсог цэцгүүд алаглан ургасан

Горхины ус нь мяралзан урссан хүүхдийн зуслан.